



## ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

### ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,  
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: 26 01 82, Цахим шуудан: info@mmra.gov.mn,

Цахим хуудас: www.mmra.gov.mn

2026.04.17 № 03/530

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Чиглэл хүргүүлэх тухай

Тус газраас эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, хангамжийн зохицуулалт хийх зорилгоор төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас нөөц, тасалдлын мэдээг долоо хоног бүр авч байгаа бөгөөд Метилдопа 250 мг шахмал эм тасалдал үүсээд байна.

Иймд бүртгүүлэгч, импортлогч байгууллагуудаас түргэн шуурхай нийлүүлэх боломжгүй талаарх мэдээлэл ирүүлсэн тул Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.1.1 дэх хэсэг, MNS 5530:2014 Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага стандартын 5.9 дэх заалтыг тус тус үндэслэн, зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалтад орсон цусны даралт бууруулах олон улсын нэршлээр Метилдопа 250 мг шахмал эмийн зах зээлд 2 сарын нөөцийг нийлүүлэх, арга хэмжээг яаралтай авч ажиллана уу.

Дээрх эмийг, импортлоход бид хуулийн тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах болно.

Хувийг: МОНГОЛЫН ЭМ ЗҮЙН БАЙГУУЛЛАГЫН НЭГДСЭН “ЭМ” ХОЛБОО, ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОЛБОО-нд

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХОНГОРЗУЛ

1526 150500